



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар A/06

Улаанбаатар хот

Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх,
ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.18, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.4, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/11 дүгээр тогтоолоор батлагдсан Багахангай дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.1.3, 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус III хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.“Дүүргийн Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхийг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрх зүй, төрийн байгуулалтын хороо (Д.Баттөр)-нд даалгасугай.

ДАРГА

Ф.МӨНХГЭРЭЛ